




Гарын авлага >>>>

# ИНТЕРНЭТ БАНК


ЦАРАЙ ТАНИН БАТАЛГААЖУУЛЖ НЭВТРЭХ

## Нэвтрэх - Царай танилт



### АЛХАМ 1



Egolomt.mn вэбсайт руу орж интернэт банкны нэвтрэх нэр, нууц үгээ оруулан "Нэвтрэх" товчийг дарна.



### АЛХАМ 2

Царай танин баталгаажуулах мэдээлэлтэй танилцаж "Зөвшөөрөх" товчийг дарна.

## Царай таниулах




### АЛХАМ 3

Таны ашиглаж буй төхөөрөмж дээр камер ашиглах зөвшөөрөл асуух бөгөөд "Allow" буюу зөвшөөрөх товчийг дарна.

### АЛХАМ 4


Зааврын дагуу царай таниулах үйлдлийг хийж, царай танилтыг баталгаажуулна.

## Царай таниулан нэвтрэх



### АЛХАМ 5

Царай танилт амжилттай хийгдсэний дараа "үргэлжлүүлэх" товчийг дарна.




### АЛХАМ 6

Таны бүртгэлтэй утасны дугаарлуу нэг удаагийн нууц үгийг илгээх бөгөөд нууц үгийг оруулан "Нэвтрэх" товчийг дарснаар Интернэт банкуу амжилттай нэвтэрнэ.

Санамж: "Би тус төхөөрөмжийг байнга ашигладаг" хэсгийг идэвхжүүлснээр дараагийн удаа Интернэт банк руу нэвтрэхэд царай танилт хийгдэхгүйгээр нэвтрэх боломжтой.

## Царай таниулахгүйгээр нэвтрэх




### АЛХАМ 5

Царай танилт амжилтгүй болсон үед та санамжтай сайтар танилцаж "Үргэлжлүүлэх" товчийг дарна уу.

\*Царай таниулах үйлдэлийг нийт 3 удаа хийх боломжтой.

Санамж: Царай таниулах үйлдлийг хийхгүйгээр "Нэг удаагийн код" ашиглан нэвтэрсэн тохиолдолд өдөрт хийх гүйлгээний эрх 1 сая төгрөг болж буурна.



### АЛХАМ 6

Нэг удаагийн нууц код хүлээн авах бүртгэлтэй утасны дугаар/имэйл хаягийг сонгож "Илгээх" товчийг дарна. Сонгосон сувагт ирсэн нууц үгийг оруулан "Үргэлжлүүлэх" товчийг дарснаар интернэт банк руу амжилттай нэвтэрнэ.

## Санамж

### ОТР кодоор нэвтэрсэн үед хандах боломжгүй цэсүүд:

- Хадгаламж цэс: Хадгаламж хаах
- Зээл цэс
- Хувийн тохиргоо цэс
- Гүйлгээ цэс: SWIFT гүйлгээ цэс
- Гүйлгээ цэс: Western Union
- Карт цэс: Кредит картын төлбөр –Бусдын кредит картын төлбөр

### ОТР кодоор нэвтэрсэн үеийн гүйлгээний лимит:

- Өөрийн данс хооронд хийх гүйлгээнд лимит байхгүй

Бусад гүйлгээний лимит нь 1,000,000 төгрөг хүртэл байна. Үүнд:

- Голомт данс хоорондын гүйлгээ
- Банк хоорондын гүйлгээ
- Өөрийн кредит картын төлбөр
- Хэрэглээний төлбөр
- Гааль, татвар, торгуулийн гүйлгээ
- Гадаад гүйлгээ

**Танд амжилт хүсье.**